



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/135

Номгон

“Өөрчлөлтийг хурдаасгая” уриан дор
“Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 2/7 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.4, 5.2, 2022 оны 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Өөрчлөлтийг хурдаасгая” уриан дор “Дэлхийн усны өдөр”-ийг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.“Дэлхийн усны өдөр”-ийг зохион байгуулж, иргэдэд экологийн боловсрол олгох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

4.“Дэлхийн усны өдөр”-ийн хүрээнд усны нөөцийн хомстол бохирдоос хамгаалах, усны чанар, зүй зохистой хэрэглээ иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, экологийн мэдлэг, хандлага, төлөвшлийг олгох олон талт ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, ажлын тайланг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б. Ням-Очир)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын нийтийн дугаар сарын
10-ны өдрийн 136 дугаар захираажийн хавсралт



**“ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ням-очир

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын
захиргааны дарга

Гишүүд:

Б.Намуун

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Зүгдоржав

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
Усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Золбоо

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит,
сургалт, сурталчилгаа хариуцсан
мэргэжилтэн

А.Өлзийсайхан

Боловсрол, шинжлэх ухааны газрын
мэргэжилтэн Сургалтын орчин, хүүхдийн
хоол үйлдвэрлэл, тэгш хамран сургалт
хариуцсан мэргэжилтэн

М.Өлзийхишиг

Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл
мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Л.Энхтогтох

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын
захиргааны Усны чанар экологи, төлбөрийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Т.Батжаргал

Насан туршийн боловсролын төвийн
Иргэний боловсролын багш

С.Цэдэнсодном

“Чандмань Баянхонгор” ХК-ний Ерөнхий
инженер

Б.Ундармаа

Улаан загалмайн холбооны Гамшиг, эрүүл
мэндийн хөтөлбөрийн арга зүйч

Нарийн бичгийн дарга: Ж.Баасансүрэн

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын
захиргааны Усны нөөцийн нэгдсэн
менежмент, сургалт сурталчилгаа
хариуцсан мэргэжилтэн

ооо